

Греймасын үйлдэгч хэмээх ойлголт ба нэгэн монгол өгүүллэг

М.Ууганбаяр
(Монгол Улсын Их Сургууль)

Abstract: In this paper, the author discussed the notion of actant and actor which are very popular in literary semiotics structuralism and narrative theory. There are six key actantial roles of functions arranged in three sorts of binary opposition: subject/object; sender/receiver; helper/ opponent. Together the six actants and their organization account for all possible relationships within a story and indeed within the sphere of human action in general. The actantial narrative schema is a simplification of Propp's seven spheres of action or roles elaborated from a study of the Russian folk tale roles such as those of hero, villain, helper etc.

The subject is what wants or does not want to be joined to an object. The sender is what instigates the action, while the receiver is what benefits from it. The helper helps to accomplish the action, while the opponent hinders it.

Semiotics uses the term actor to refer to any individual, anthropomorphic or zoomorphic agent, to a group or to an abstract entity such as fate. In semiotic analysis actor has replaced the traditional terms of character or protagonist. Actors individualized and represent concrete figurative elements.

On the example of the modern Mongolian love story, Hulan and I by Sengiin Erdene can be thought that the characters Tsamba and Sampil as actors become subject and receiver and Hulan as an actor becomes object and sender.

Аристотель “Туурвил зүй”-дээ үйлдлийг эрхлэгч гүйцэтгэгч болох нөхцөлд л зан төрх шаардлагатай болно гэж үзжээ (Аристотель 1951:34). Энэхүү үзлийг формалист структуралист туурвилзүйчид дэмжсэн билээ.

Уугуул хэлний үйл үг төвтэй хэл зүйд суурилсан хүүрнэмжийн хэл зүйн байгууламжид үйлдэл дагах нь хялбар учир зан төрхийг үйлдэлд хураангуйлан буулгах нь тохиромжтой байжээ.

В.Пропп зан төрхийг үйлдлийн хүрээнд захируулахдаа гүйцэтгэмжийг долоон ерөнхий үүргээр ангилжээ.


Энэ нь
хорлогч,
хандивлагч,
туслагч,
хайгдаж буй хүн түүний эцэг,
илгээгч,
баатар,
хуурамч баатар
болно. (Пропп 2001:73)

А. Ж. Греймас, В. Проппын долоон үйлдлийн хүрээг гурван хос эсрэгцэл болгож хурааж болохыг, энэ нь аливаа хүүрнэхүйн бүтцийг дүрсэлдгийг

тодруулжээ. Эл гурван эсрэгцэл нь субъект объект /Проппын баатар ба хайгдаж буй хүн/, илгээгч хүлээгч /Проппын илгээгч ба баатар/, туслагч сөрөгч /Проппын туслагч, хандивлагч, хорлогч, хуурмаг баатар / болно (Чандлер 2006:96)

Субъект нь эрх хайж байгаа хэн нэгэн бол. объект нь хайж буй тэр зүйл юм. Илгээгч объектыг илгээж, хүлээгч нь хүрэх газар нь болж, туслагч үйл явдалд тусалж, сөрөгч үйл явдалд хориг болдог ажээ.

Греймасын үйлдэгч нь бүх эхийн суурь болох түгээмэл хүүрнэмжийн бүтэц юм. Энд энэхүү зургаан үйлдэгчийн үүрэг буюу үйлдэмж нь хос эсрэгцлийн гурван цогц бүрдэлд зохион байгуулагдана. Энэхүү зургаан үйлдэгч тэдгээрийн зохион байгуулалт нь өгүүллэгийн дотор болон ерөнхийдөө хүний үйл явдлын хүрээний дотор бүхий л боломжит харилцааг илрүүлнэ.




Эдгээр хүүрнэмжийн байрлалууд хүн, орон байр, объект, хийсвэр санаагаар илэрч болно. (Мартин, Рингхэм 2006: 20)

Ийнхүү Греймас бүх хүүрнэмжийн сэдэв, үйл явдал, зан төрхийн үндэс суурь болж байдаг үйлдэгчийг авч ярьжээ. Үйлдэгч гэдэг нь үйлдэл хийж эсвэл үйлдэлд өртөх хэн нэгэн юм уу ямар нэгэн юмыг заана. Бие хүн антропоморф, зооморф агент, ямар нэг юм эсвэл хийсвэр зүйл тус тус үйлдэгч байж болно.


Гүнд байх үйлдэгчийн загвар болон энэхүү гүнд байх бүтцээс хувирсан хувь өгүүлэгүүдийн өнгөн бүтцийг хос эсрэгцлүүд хэлбэржүүлнэ. Товчхондоо хүүрнэмжийн гүн бүтэц өгүүллэгийн өнгөн агуулгын цаад талын нэг түвшинд үйлдэгчдээ үүсгэж тодорхойлно. Энэ нь Ф. де Соссюрын хэл нь хэлэхүйн үндэс болно гэх юм уу Н. Чомскийн чадамж нь гүйцэтгэмжийг урьдчилна гэсэнтэй адил юм. Үйлдэгчид нь хэлэхүйн бус хэлний гэдэг шиг авианаас илүү авиалбарын үүрэгтэй байж агуулгаас илүүтэй үйлдэмжийн түвшинд хэрэгжинэ. Энэ нь тодорхой зан төрх буюу хийгчид өөрийгөө биежүүлэх нэг үйлдэгч хүн эсвэл өгүүллэгийн үндэс суурь болж буй эсрэгцсэн бүтцийн нэгдсэн үүргийн дагуу нэгээс илүү зан төрхийн үйлдэмжтэй ч байж болно. (Хоукес 1977:71)

А. Ж. Греймас субъект, үйл үг, объект гэсэн бүтцээс өөр хэсэг рүү шилжүүлж өгүүллэгийн бүтцийн үндэс болгож үйлдэгчийн загварыг санал болгожээ. Тэрбээр “уламжлалт өгүүлбэр зүйд үйлдэмж нь үгийн үүрэг болох ба субъект үйл явдлыг үйлдэгч байж объект нь түүнд автагдах хэн нэгэн байдаг” гэжээ. Өгүүллэгүүд ийнхүү нэгдмэл хэл зүйг бүрдүүлдэг байна. (Чандлер 2002:96)

Энэхүү үйлдэгчийн загвар сонгодог үеийн эрдэмтэн философичийн танин мэдэх үйл явцын тухайд



гэж, хүнд туслах хүсэл, тэмцэгчид харагдах байдлаараа марксист үзэл суртал



гэсэн байдалтай байх ажээ. (Греймас 2000:153-170)

А. Ж. Греймас зан төрхийг үйлдэлд захирагдахыг үйлдэгч гэж нэрлэжээ. Греймас үйлдэгч /actant/ хийгч /actor/ хоёрыг ялгасан бөгөөд энэ хоёр ойлголт хоёулаа хүн буюу зан төрхийг заахаас гадна амьгүй юмс /ид шидийн бөгж/ хийсвэр ойлголтыг /хувь заяа/ илэрхийлнэ. Үйлдэгч нь бүх хүүрнэмжийн суурь болж, хийгч нь янз бүрийн хүүрнэмжид тусгай шинжүүдээр хангагддаг (Риммон Кенан 2000:35).

Тэмдэг судлалын задлалд хийгч нь зан төрх, гол баатар гэсэн уламжлалт ойлголтыг орлох болов. Хийгч нь хувь хүнжсэн ба тодорхой дүрслэг махбодуудыг төлөөлдөг. “Үнсгэлжин” үлгэрт Үнсгэлжин, түүний эгч нар, шидэт загалмайлсан эх, ханхүү тэргүүтэн гол хийгчид болно.

(Мартин, Рингхэм 2006: 20)

Хүүрнэмжийн гүн бүтцийн түвшний үндсэн үүрэг болохын хувьд үйлдэгч нь зан үйлдэл хийхүйн суурь болох бол хийгч нь янз бүрийн хүүрнэмжид илэрнэ.

King Arthur sends Perceval to kill the dragon in exchange for a beautiful diamond

Артур хаан Персэвалыг гоёмсог очир чулууны оронд лууг хөнөөхөөр илгээв.

гэсэн өгүүлбэрийг авч үзэхэд Артур Персэвал луу очир чулуу нь хийгч болно .

Харин үйлдэгчийн хувьд илгээгч Артур хаан Персевал гэх субъектийг сөрөгч болох лууг гоёмсог очир чулуу гэх объектээр солихоор явуулж байна.

Өөрөөр хэлбэл үйлдэгчийн утгатай юм нэг хийгч хүүрнэмжийн янз бүрийн мөчид янз бүрийн үйлдэгч болж болох ба нэг үйлдэгч янз бүрийн хийгчээр илэрч болно. Хүүрнэмжийн өнгөн бүтцэд нэг үйлдэгч хэд хэдэн хийгчээр илэрч болно. Риммон Кенаны бүтээлд үйлдэгч хийгчийн жишээг үзүүлжээ.

Pierre and Paul give an apple to Mary

Пьер Поль хоёр Мэрид алим өгнө

гэх өгүүлбэрт Пьер Поль хоёр нь тус тусдаа хийгч болж илгээгч гэсэн нэг үйлдэгч болж байна.

Мэри бол хийгч болохын хажуугаар хүлээгч гэсэн үйлдэгч болж байна.

Pierre buys himself a coat

Пьер өөртөө хүрэм худалдан авна

гэсэн өгүүлбэрт Пьер нь нэг хийгч илгээгч хүлээгч гэсэн хоёр үйлдэгч болж байна. (Риммон Кенан 2000:35)

Бид үйлдэгчийн жишээ болгож С.Эрдэнийн “Хулан бид хоёр” хэмээх хайр дурлалын сэдэвтэй өгүүллэгийг авч үзвэл Цамба Сампил гэх хоёр хийгч субъект ба хүлээгч гэсэн хоёр үйлдэгч болж харин Хулан гэх нэг хийгч объект ба илгээгч гэсэн хоёр үйлдэгч болно.

С. Эрдэнэ "Хулан бид хоёр"

(Өгүүллэг)

Арван долоон нас ч дээ. Хөөрхий зайлуул. Би тэгэхэд өөрийгөө эр хүнд тооцож явжээ. Гэтэл тэр зун ёстой шалчгар эр болохоо мэдсэн юм. Долдугаар сарын нэгэн өдөр би нутгийнхаа Чингис хаан болоод түүний залуу гэргийн хамт сумынхаа наадамд очихоор эртлэн мордлоо. Гэр Чингис хаан гэдэг маань ердөө л шар Цамба юм шүү дээ. Би түүнд ийм догшин сүртэй хоч өгсөн боловч хүнд хэлдэггүй байлаа. Хурдан морь уяхад нь би түүнд туслалцсан юм. Тэгэхэд над шиг жулдрай амьтан салхин зээрд, цахилгаан хээр гэх мэт үлгэр домгийн нэртэй тэр сүрхий хөлөг морьдыг нь үдшийн чийг буусан хойно хээр аваачиж идээшлүүлэх, өглөө үүрээр чилээгий нь гаргах, өдөр услах зэрэг хар бор ажил хийхээс өөр ямар тус хүргэх билээ.

Шар Цамба гэгч гуч эргэм настай, ирвэснийх шиг жоотгор шар нүдтэй, буржгар хүрэн үстэй, дундуураа ховилтсон урт эрүүтэй бөгөөд майгавтар богинохон хөлөө бат гишгэж нударгаа үргэлж зангидаж явдаг хүн. Шар нүд нь урин зөөлөн харцтай байхыг би ер үзсэнгүй. Нусгай жаалууд бол түүний харцнаас айж хулганан, мөрөө хавчиж, модон өмд өмссөн юм шиг хөдлөхгүй

болно. Цамба адуу мал, алт мөнгөөр баян бөгөөд морь арилжих дон туссан хүн. Хавар ногоо цухуйнгуут хэдэн морь сайн эмээл тохож, сайхан хувцас өмсөөд л хуй салхи мэт арилж өгнө. Тэгээд Хэрлэн Баян-Улаан, Гал шар бүр Дариганга хүртэл доншуучлаад ид зун болсон хойно сайн сайн морьдыг хатир жороо, өнгө зүсээр нь ижилсүүлж хөтлөөд, уулын бэлээр тоос татуулж уртын дуу уянгалуулсаар буцаж ирнэ. Шар Цамбын ид хав ийм л байлаа. Манай нутгийнхны зарим нь түүнийг цагаан омогтой, хийморьтой, сайн эр гэх боловч олонх нь онгиргон сагеуу, олиггүй хүн гэлцдэг билээ. Харин би бол түүнийг Чингис хаан шиг л хүн гэж бодно.

Бид үүр цүүрээр өмнө зүг давхиж явлаа. Сумын төв хүртэл хоёр өртөө газар, зам их бартаатай. Жирэмийн даваа гэж нэг их даваа буй. Нар цухуйхын алдад Чингис Цагаан тохойн айлаар бууж дөрөө чангална гэж бид хоёрыг орхиод жилийж одов. Тэгэнгүүт би дотроо нэг л баяртай боллоо. Арван долоон насанд, үгүй дээ л эр хүний үнэр орсон байх шүү дээ. Шар Цамбын эхнэрийг Хулан гэнэ. Хулан холын нутгаас хадамд ирсэн, сар шиг сайхан, салхи шиг тогтворгүй амьтан билээ.

Ахыгаа дагаж аймаг руу хоёр жил хэртэй яваад энэ хавар нутагтаа буцаж ирэхэд минь Шар Цамба ийм залуу сайхан эхнэр авсан байлаа. Цамба эхнэрээ үргэлж занчиж, үүр шөнөөр чарлуулж байдаг гэж манай нутгийнхан ярилцаж байлаа. Гэвч би тийнхүү чойжин буулгаж байхыг нь үзсэнгүй.

За тэгээд Чингис хаан бараа сураггүй болжээ. Би наадамд уралдуулахаар сойсон дөрвөн сайхан морий нь хөтлөөд Хулан хүүхний дэргэд цогиулж явлаа. Өглөөний сэрүүнд ээгсэн эргүүлээд Жирэмийн даваа даваарай гэж «хаан» бидэнд тушаасан юм.

Би Хулан хүүхнийг хулгай нүдээр шохоорхон харж ер бишийн баяр хөөртэй явав. Ингээд л давхиад байвал хаа ч хүрч болмоор санагдана.

Наран цэлмэгт мандаж, салхин өмнөөс сэрчигнэнхэн уулын энтээ сүүдэр тусаж байхад, өрнө уулын ташланд улбар туяа тусжээ. Нуга газрын шүүдэрт ногоо хөлд шир шир хийж, урдах зам дээрээс болжмор шувуу байн байн ниснэ.

Хулан хүүхэн улаан савхин гутал өмсөж, жижигхэн хөлийнхөө өлмийг хотойлгон жийжүү дөрөө жийж, хөх торгон тэрлэгийнхээ хормойг өвдөгнөөсөө дээш цугларуулж, торгон оймсны цаана туяарч байгаа чийрэг булчингаа чангахан ороогоод, боржгин хийцтэй эмээл дээр янзтайхан сууж, шар дурдан бүс эвлэгхэн ороосон нарийхан бэлхүүсээ жороо хүрнийхээ явдлын аясаар үл мэдэг нахилзуулан явна.

Магнай дээрээ сартай жороо хүрэн морь мөнгөн товруут хазаарынхаа амгайг соёондоо өлгөж хазаар даран тэмүүлэхэд үс нь илбүүршсэн тэгшхэн зоо нь үл мэдэг жирвэлзэхийг үзвэл аягатай ус тавьсан ч асгармааргүй, морь эзэн хоёрын энэ байдал хөгжмийн хөг таарах мэт сэтгэлд маш тааламжтай.

Харин, миний өмссөн хувцас гэвэл, эмжээр нь сэмэрсэн ногоон жигүүн тэрлэг, өвдөг дээрээ зууван нөхөөстэй цэрэг өмд, хугархай саравчтай хуучин муу малгай, унасан морь гэвэл, Чингис хааны адуун сүргийн адаг, ааш муутай алаг үрээ байлаа. Хулан, уулын орой харж уянгат дуу аялж явснаа намайг нүднийхээ булангаар

харж доогтойхон инээмсэглээд,

- Сампил аа чи дуулаач гэхэд миний царай яах ийхийн завгүй улаа бутраатахлаа. Өнчин хүн дуулаач гэгчээр би тэрүүхэндээ л зэгсэн хоолойтой байжээ. Адуу малд явахдаа дуу аялж хадны цууриа чагнадаг өвчтэй юмсан. Би сүүндээ цадсан тугал шиг хэлээ долоож, эхлээд тун онхио муутайгаар «Ар Хянган уулан дээр нь гараад харахад» гэдгийг дууллаа. Хулан намайг ингэж дуулна гэж огтхон ч санаагүй тул морио татаж сайхан алаг нүдээ тормолзуулан мишээв. Тэгэхээр нь би урам зориг орж, ухаан, хоолой хоёрынхоо чадлыг шавхаж харь хол явсан хайрт ганц охиноо мөрөөдсөн эхийн тухай дуулав. Тэгтэл Хулан ханцуйнаасаа алчуур гаргаж нулимсаа арчив шүү. Би амаа ангайсан хэвээрээ таг боллоо. Ингэж уярах юм гэж ер санасангүй.

- Сампил аа дуулаач дээ гээд Хулан бүр мэгшин уйллаа. Гэвч миний дуулах сэхээ алга болжээ. Хулан нэлээд удаан уйлаад сая тайтгарч энэ удаа аятайхнаар хараад,

- Сампил чи ямар сайхан дуулдаг юм бэ гэхэд би аанай л ичиж улайлаа.

Даваан дээр гарах үес бага үд болжээ. Энэ хооронд Хулан бид хоёр бие биеэ овоо мэдэх болсон байлаа. Хулан бас надтай адил өнчин хүн юмсанжээ. Бид овооны дэргэд буулаа. Энэ өдөр аагим халуун боловч давааны өндөрт салхи сэрүүн бөгөөд шилмүүст ойн содон үнэр анхилж, тэртээ дор хөх ногоон шугуй дундуур урсах Онон голын нугалаанууд гялалзан, мэлтэлзэн харагдав.

Хулан зулай даран ороож чихний тус зангидсан улаан пансан алчуураа авч махлаг цагаан гараараа магнайгаа илээд намайг ширтэж юу бодсоныг бүү мэд нэг л донжтойхон инээмсэглэнэ. Энэ үед би Чингис хаан мөд бүү ирээсэй гэж бодож байсан тул байн байн зам руу харжээ. -Чи юугаа хараа вэ? гэж хүүхний гэнэт асуухад -Чингис... хэмээн санамсаргүй хэлж орхилоо.

- Юу-у? гэж гайхан харахад нь би бүр бантаж орхиод

- Аа-а тийм... Чингис... үгүй ээ ца.. ца.. гэж бувтнаад мангуу юм шиг маасайтал инээхэд Хулан улам гайхаж

- Юун Чингис вэ? гээд нүдээ томоос том болголоо. Би сая л нэг хэлээ татагчаан болж

- Үгүй, Цамба гуай гүйцэж ирэх болоогүй юм аа? гэв. Хулан бас л гайхсан хэвээрээ,

- Тэгээд Чингис, Чингис гээд байдаг.. гэхэд нь би одоо дүүрсэн хэрэг гэж бодоод,

- Цамба гуай Чингис хаантай төстэй шүү гэтэл

- Юу гэнэ ээ? гээд гэдрэг унан хөхөрч,

- Үхсэн хойноо Чингис хаан бол. Чингис шиг баатар бол адаглаад эхнэрээ зодохгүй байхсан. Тэр чинь одоо ногоорч л яваа биз. Энэ шөнөдөө сум хүрч чадвал дээд заяа гээд санаа алдан ногоон дээр хажуулдан ил гарсан өвдгөө хормойгоороо ороогоод, нэг ширхэг хялгана тасдан амандаа зууж ямархан нэг зүйлийг мөрөөдөн санаашрах мэт нүдээ аньж байснаа аальгүйтэн инээж,

- Намайг тат! гээд гараа өгөв. Түүний гар зөөлхөн бөгөөд бүлээхэн байлаа.

Хулан тэр даруй мориндоо мордож,

- Сампил аа эрчээрээ давхиад гол дээр очъё. Усны эрэг дээр их сайхан байгаа.

Цамба мөд ирэхгүй, явъя! гэж хөгжилтэй хэлээд мориндоо ташуур өгч даваа руу жороолуулав. Би ч яаран мордож хойноос нь давхив. Сампил аа дуулаарай гэнэ. Би сэмэрхий ногоон тэрлэгнийхээ хормойг хийсгэнхэн,

- Эр ээ боруу харцагана нь үү-ээ

Жигүүрхэндээ хүчтэй ай хө алдрай мину зээ.. гээд л Жирэмийн давааг жингэнэтэл дуулж явлаа. Гол дээр хүрч ирэхэд нөгөө хурдан морьд маань хүртэл хөлөрчихсөн байв.

Хулан намайг хүн бараг явахаа больсон, хуучин гарам тийш дагуулж очив. Бид хоёр улиас бургас, мойл долоогоно хосолсон битүү шугуйн дунд бууж морьдоо уяд тухтайхан хүүрнэж суулаа...

Чухам юу гэгч болж байгааг би мэдэхээ байжээ.

- Хулаан манай нутагт чам шиг сайхан хүүхэн байхгүй шүү.

- Над бас өөр сайхан юм бий л дээ.

- Юу гэж?

- Яагаав. Сэтгэл байна.

- Тэгээд жаргалтай амьдарч...

- Чи бод л доо. Би хүний эрхэнд байна. Зовлонгоо нуухыг л бодох юм. Хүн намайг жаргалдаа ташуурсан амьтан гэж боддог.

- Хулаан, чи ингэж амьдрах ёсгүй, салаад яв! Чамайг сүрдүүлдэг байхгүй юу. Хаяад явчихвал чинь яаж ч чадахгүй.

- Сампил аа, чам шиг хүнтэйсэн бол ... чи даанч ичимтгий юм даа. Намайг үнс л дээ ...

Бидний хажуу дахь бургасны мөчир дээр ирж суусан бяцхан бор бялзуухай «эд ер нь яаж байна» гэсэн байртай толгойгоо гилжийлгэн шил сувс шиг өчүүхэн нүдээ эргэлдүүлнэ.

Хулан гараа дэрлэж нүдээ аниад,

- Намар чиний аймаг орсон хойно би Цамбаас салаад бас аймаг орно. Ажил хийвэл амьдарна шүү дээ. Би оёдолчин, үгүй дээ цэвэрлэгч хийж дөнгөх байлгүй. Тийм ээ Сампил аа?

- Тийм ээ. Би бол тракторчин юм уу жолооч болох санаатай! Хулаан! Энэ шувуу ямар хөөрхөн нүдтэй юм бэ!

Шинэ гармын замд орох үед нэгэнт орой болсон байлаа. Гэвч бид Чингис хаан нөгөө цагаан тохойдоо л ногоорч яваа гэж ажиг сэжиг ч үгүй явлаа. Хэчнээн баяр жаргалтай явсан гэж санана. Хулан миний мөрийг түшин мишээж, би эр бор харцага аялан мишээж, оройн наран уулын толгой дээр мишээнэ.

Сайр шандын усыг шавхаж яагаад барах вэ?

Сайн хүний үртэй дэмий л юундаа даслаа даа ...

Бид хоёрын урдаас ямар нэг хүн улаан тоос татуулан давхиж айсуу. Хулан гэнэт морио татаж тэр хүний зүг түгшүүртэйгээр ширтээд,

- Цамба ирж явна гэж шивэгнэв. Би ч дорхноо шалчийж орхилоо Зүрх маань амаараа гарах нь ээ.

- Хаанаас даа энэ чинь сумаас нааш ирж яваа хүн байна.

- Мөөн, мөн, яах аргагүй мөн. Бидний тэнд байх хооронд сум орж л дээ

- Одоо яах вэ?

- Харин ээ... Гол дээр бууж морьдоо амраасан гэхээс

- Ийм удаан уу...

- Харин ээ...

Догшин Чингис хаан ч юу юугүй хүрээд ирлээ. Тэр бид хоёрт тулж морио татаад ирвэсний шар нүдээрээ муухай харлаа. Энгэр заам нь задгай, царай нь хөөнгө, эмээл дээрээ хажуулдан бүдүүн тэнзэн ташуураа морин дэл дээр хөндөлдүүлэн барьжээ.

- Чи сумаас ирэв үү? гэж Хулан их л тулгамдан асуухад Цамба шүдээ тачигнатал хавираад, амаа муруйлган

- Сумаас гэнэ шүү. Энэ зулбадастайгаа шугуй дотор хэвтэж байхад чинь...

- Битгий дэмийр чи...

- Дуу! гэж Цамба муухай хашгираад над руу дайрч яах ийхийн завгүй морин дээрээс минь хуу татаж орхиод

- Муу новш хүний морь унаад бас эхнэрий нь...

- Цамбаа! Чи ямар жигтэйхэн амьтан бэ! гэж Хулан уйлагнан хашгирав.

Цамба галзуурсан юм шиг шар нүдээ эргэлдүүлэн шүдээ ярзайлгаж

- Дуу! Наана чинь нам цохино шүү гэж орилоод цулбууры нь шүүрэн авч морийг нь ташуурдав.

- Би бууна. Би үхсэн ч чамтай явахгүй гэж Хулан хорсон уйлахад

- Чи тэг. Харин би цаадах нусгай жаалыг чинь нэг л цохино шүү гэж Цамба бороохой мэт бүдүүн ташуураа далайн над руу давшлахад,

- Цамбаа, болиоч! гээд Хулан гараас нь зуурав. Би гэдэг хүн ухаан балартах шахам, газар зоосон гадас шиг хөдлөлгүй зогсож байжээ. Цамба үсрэн бууж морьдоо Хулангийн морины хүзүүнээс холбоод мөн л харайн мордож, Хулангийн цулбуурыг шүүрч аваад, морьдоо хайр найргүй ташуурдан давхив. Миний өмнө улаан тоос манарч, хөөрхий Хулангийн хорсон уйлах чимээ тасарлаа.

Би зам дээр явган хаягдсанаа сая ухаарч Цамбын хойноос гар зангидан,

- Би чамаас хариугаа авна даа. Заавал авна! Хулан ч чамайг хаяна. Үзээрэй, муу нохой! Хулан чамайг заавал хаяна! гэж нулимсаа арчиж нусаа татсаар хоцорч билээ.

Ном зүй

1. Греймас А.-Ж. “Размышления об актантных моделях” *Французская семиотика: От структурализма к постструктурализму* Пер. с фр. и вступ. ст. Г.К. Косикова. Москва: Прогресс. 2000
2. Греймас А.-Ж. *Структурная семантика: Поиск метода* Пер. с фр. Л. Зиминой. Москва : Академический проект. 2004
3. Пропп В. Я. *Морфология волшебной сказки*. Москва: Лабиринт. 2001
4. *Французская семиотика: От структурализма к постструктурализму* Пер. с фр. и вступ. ст. Г.К. Косикова. Москва : Прогресс. 2000
5. Эрдэнэ С. Хулан бид хоёр *Шилмэл өгүүллэгүүд*. Улаанбаатар 1988.
6. Aristotle *Poetics* in Smith James Harry and Parks Edd Winfield (eds) *The Great Critics: An Anthology of Literary Criticism* New York: Norton 1951

7. Chandler D. *Semiotics: The Basics*. London: Routledge. 2002
8. Greimas, A. *Structural Semantics*. Lincoln, NB: University of Nebraska Press. [1966] 1983
9. Greimas A. *On Meaning: Selected Writings in Semiotic Theory* trans. Paul J
10. Perron & Frank H Collins. London: Frances Pinter. 1987
11. Hawkes T. *Structuralism and Semiotics* London: Methuen 1977
12. Martin B., Ringham F. *Key Terms in Semiotics*. Continuum London&New York. 2006
13. Propp V. *Morphology of the Folktale* (trans. Laurence Scott, 2nd edn.). Austin: University of Texas Press.[1928] 1968
14. Rıfat M. *Göstergebilimcinin Kitabı*. İstanbul: Düzlem Yayınları.1996
15. Rıfat M. *Göstergebiliminin ABC'si*. İstanbul: Say Yayınları. 2009
16. Rimmon-Kenan Sh. *Narrative Fiction*, Routledge.2002